

## Хэнтий аймгийн Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбооны

### 2017 оны 8-р сараас 2018 оны 7-р сард хэрэгжүүлсэн ажлын тайлан

Хэнтий аймгийн Мөнгөн хуримтлалын бүлгүүд энэ жилийн Олон улсын хүний эрхийн өдрийн арга хэмжээг Хэнтий аймгийн Иргэний Нийгмийн байгууллагын сүлжээ, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран ТХ-зорилт 8-ын Эдийн засгийн өсөлт баталгаат ажлын байрыг бий болгох гэж заасны дагуу “Баталгаат ажлын байрыг бий болгоё” сэдвийн дор тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээний хүрээнд 2017 оны 12-р сарын 1-6 өдрүүдэд Хэнтий аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 54 аж ахуйн нэгжүүдээр ИНБ-ын 18 байгууллага 6 багт хуваагдан ажил олгогч, ажилтан нартай уулзаж хөдөлмөрийн гэрээтэй ажилладаг эсэх талаар судалгаа авч, зөрчлийн тухай хуулийн зүйл заалтыг танилцууллаа.

2017 оны 12-р сарын 8 –ны өдөр Хэнтий аймгийн иргэний танхимд ажил олгогч, ажилтан, бүлгийн гишүүд, иргэдэд хөдөлмөрийн гэрээ гэж юу байдаг, гэрээ байгуулсаны ач холбогдолыг танилцуулсан болно. Уг арга хэмжээнд Хэнтий аймгийн мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн улсын байцаагч Тогтох, Э.Эрдэнэцэцэг нар оролцон мэргэжлийн зөвлөгөө мэдээлэл өгч, асуусан асуултанд хариулсан нь үр дүнтэй боллоо. Мөн Өндөрхаан ТВ, Хэнтий ТВ, Хэнтий мэдээ сониныг урьж үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан болно. Хэнтий мэдээ сонинд 4\1 хэмжээтэй мэдээлэл нийтлүүлэн олонд түгээсэн болно. Мөн Олны хүч бүлгийн гишүүд цагаа буцалгаж оролцогч нарыг халуун цагаагаар дайлсан болно.

Тус үйл ажиллагааг хамтран зохион байгуулахад идэвхтэй ажилласан Хэнтий аймаг дахь ХАУТанхим, ХБИХолбоо, Малчин эмэгтэйчүүдийн холбоо, Ахмад багш нарын холбоо, аймгийн ҮЭ, Ногоочдын холбоо, Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан Хүний Эрхийн үндэсний комисс Д.Эрдэнэбаясгалан болон бусад байгууллага, бүлгийн гишүүддээ талархлаа илэрхийлье.





Холбооны гишүүд хэлэлцүүлэгийн дараа



ХЭҮК Д.Эрдэнэбаясгалан

Хэнтий аймгийн Мөнгөн Хуримтлалын бүлгүүдийн холбоо 2018 онд уламжлал болон хийгддэг ажлуудаа хэрэгжүүлж ирлээ. Цагаан сарын золголтыг олон улсын эмэгтэйчүүдийн баярын хамтад нь тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ үйл ажиллагааг зохион байгуулсанаар бүлгийн гишүүдийн хамт олонч байдал, ахмад настангуудаа хүндэтгэх зэрэг сайн талтай юм.



Хэнтий аймгийн МХБХолбооны хувьд ахмад эрх болон тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар уулзалт хэлэлцүүлэг, сургалт зэргийг зохион байгуулж ажиллаа. Үүнд

2018 оны 4-р сарын 6-ны 11,00 цагаас Хэнтий аймгийн иргэний танхимд Дэлхийн эрүүл мэндийн өдрийг тохиолдуулан “Ахмадын эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрх” сэдвээр уулзалт хэлцүүлэгийг Хэрлэн сумын ахмадууд болон МХБХ-гишүүдийн дунд зохион байгууллаа. Энэ жилийн хувьд бид ахмадын эрүүл мэндийн асуудал, хүчирхийлэл, үл тоомсорлолт, ёс бус харьцаа, ялгаварлан гадуурхалт, алив дарамтаас ангид тэгш эрх эдлэх, эрх чөлөөний асуудлаар ярилцлага өрнүүлэн бүлгээр ажиллаа. Хэлэлцүүлэгийг дараах байгуулагууд хамтран зохион байгуулав.

1. ХЭХТ-ийн харъяа Хэнтий аймгийн МХБХ
2. Хэнтий аймгийн Ахмадын хороо
3. Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар
4. Хэрлэн сумын Ахмадын хороо

5. Хүний эрхийн үндэсний комисс

6. ХХҮГ-ын халамжын хэлтэс

Тус хэлэлцүүлэгийг аймгийн ахмадын хорооны дарга Адъяа, МХБХ-дарга Д.Уранчимэг нар нээж үг хэллээ. Help Age International олон усын байгууллагын товч мэдээлэлийг Д.Уранчимэг миний бие танилцууллаа. Ахмадын тухай хууль болон эрхийн талаарх мэдээлэлийг ахмадын хорооны дарга Адъяа, гадаадын орны ахмадуудын эрх, туршлага, хэрхэн эрхээ эдэлдэг талаар Хүний эрхийн үндэсний комиссын ахлах шинжээч Д.Эрдэнэбаясгалан, ахмад настаны эрүүл мэндийн асуудал, тулгамдаж буй асуудал сэдвээр Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Х.Мөнхзул, Ахмадуудад төрөөс үзүүлж байгаа хөнгөлөлт, халамжын үйлчилгээний талаарх мэдээлэлийг ХХҮГ-ын нийгмийн хэлтэсийн дарга Э.Хонгорзул нар тус илтгэл тавьж ахмадуудын сонирхсон асуултанд хариуллаа. Оролцогчдыг 4 бүлэг болгон хөдөлмөрлөх эрх, ахмад настаны эрхийн зөрчлүүд, эрүүл мэндийн тусламжын тулгамдаж буй асуудал, хүчирхийлэл, эрхээ эдлэхэд саад болж байгаа зүйлүүд сэдвээр бүлгийн ажлыг зохион байгуулж зөвлөн чиглүүлэгчээр Адъяа, Х.Мөнхзул, Д.Уранчимэг, Д.Эрдэнэчимэг нар ажиллаа.



Хэлэлцүүлэгт оролцогчид



Хэлэлцүүлэгт оролцогчид



Багаар ажиллаж байгаа нь



2018 оны 3-р сарын 31 нд хэнтий аймгийн ГБХЗХГазараас зохион байгуулсан Хэнтий аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөгөөнд холбооны гишүүдийн хамтаар оролцож гэр бүл, хүүхэд хөгжлийн талаар зөвлөгөө лекц сонсож санал бодлоо солилцлоо.



### Уулзалтанд оролцогчид

Хэнтий аймгийн Мөнгөн хуримтлаын бүлгүүдийн гишүүд болон хувиараа оёдол, гутал, гар урлал зэрэг жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн даатгал болон татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх зээл тусламжинд хамрагдахад оршино.

Тус уулзалт өдөрлөгийг Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хас банк зэрэг газруудтай хамтран зохион байгууллаа. Нийгмийн даатгалын хэлтэсийн мэргэжилтэнүүд бүрэн бүрэлдэхүүнээр ирж хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэр үзэж зөвлөгөө өгөх, ЭМД, сайн дурын даатгал, НД-ын тухай хуулинд орсон өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл хийлээ. Татварын хэлтэсээс улсын байцаагч Б.Ундрахтуяа татварын тайлан гаргахад анхаарах асуудлууд, татвар төлсөний ач холбогдол, Е баримтын талаар мэдээлэл хийж оролцогчдын сонирсон асуултанд хариулт өглөө. Хас банкны захирал Э.Жаргалсайхан санхүүгийн эрүүл мэнд, мэргэжилтэн Б.Жаргалмаа банкны

бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл сургалт, ХХҮГ-ын төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн А.Пүрэвдолгор 2018 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн тухай мэдээлэлийг тус тус өгч оролцогчдын асуулаганд хариуллаа. Энэ уулзалтыг сургалт мэдээлэлийн хэлбэрээр зохион байгуулсан нь оролцогч нарт их үр дүнтэй мэдээлэлийг нэг дороос авах боломжыг бүрдүүлсэн сайхан сургалт боллоо гэж дүгнэсэн байна.

Мөн бүлгүүдийн тайлан хуримтлалын талаарх дэлгэргүй мэдээлэлийг хийж энэ онд бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлэх 1+1 бүлгийг шинээр үүсгэн байгуулах, зуны туршлага судлах уулзалтанд хамт олноороо оролцох зэрэг дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.



Нээлт Хас банкны захирал Э.Жаргалсайхан



Санхүүгийн эрүүл мэнд сургалт



Сургалтанд оролцогчид



ажилласан жилийн талаар зөвлөгөө авч байна





Нийгмийн даатгалын мэргэжилтэнүүдээс зөвлөгөө авч байгаа нь

2018 оны 4-р сарын 22-23 нд Улаанбаатар хотод Хүний эрх хөгжил төвөөс зохион байгуулсан Тогтвортой хөгжлийн зорилгууд 2030 сургалтанд Хэнтий аймгаас 3 –уулаа оролцон ТХЗ-уудын талаарх мэдлэгээ сайжруулан цаашид орон нутагтаа ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд холбооны зүгээс иргэд олон нийтийг оролцуулах, мэдээлэл өгөх ажлуудыг хийх хэрэгтэй юм байна гэдгийг ойгож мэдэрлээ.



2018 оны 5-р сарын 8-9 нд Хэнтий аймагт ХЭХТ болон Монфемнетийн төслийн багийн хамт олон хүрэлцэн ирж орон нутагийн засаг захиргаа иргэд, олон нийтийн бүлгүүдийн хамтын ажиллагаа ТХЗ-уудын талаарх сургалтыг зохион байгуулж бүлгийн гишүүд болон төрийн албан хаагчдын хамт зохион байгуулж оролцлоо. Бүлгээр ажиллаж, цаашид хэрхэн ажиллах талаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг 2 удаа хуралдаж бичиг баримтын судалгаа хийх талаар ярилцлаа.



Сургалтанд оролцогчид



Ажлын хэсгийн уулзалт

Хүний эрхийн үндэсний комиссийн гишүүн Оюунчимэгтэй ИНБ-ын төлөөлөлүүд уулзаж ярилцлаа.





2017-оны 8-р сараас 2018 оны 7 –р сард Хэнтий аймгийн Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбоо дээрх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Бүлгийн гишүүд, бүлгүүдийн идэвх оролцоо хангалтгүй, хуримтлалаа цаг хугацаандаа өгдөггүй зэрэг дутагдалууд байсаар байна.

ХЭХТ-ийн 20 жилийн ойг угтаж манай холбоо 1+1 арга хэмжээг 5-р сараас 9-р сарын хугацаанд хэрэгжүүлж ажиллана. Энэ нь нэг бүлэг дахин нэг дүү бүлэг шинээр үүсгэн байгуулах ажил зохион байгуулах юм. Мөн хуримтлалын тооцоог хийж дуусгах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Тайлан гаргасан: МХБХ дарга Д.Уранчимэг